



БОЛОВСРОЛЫН ЯАМ
УЛСЫН /АХЛАХ/
БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 08-04-05

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Боловсролын давалгаа төрийн бус байгууллагын 2024 оны 09 дүгээр сарын 02-ний өдрийн 24/19 тоот албан бичиг, хүсэлтийн дагуу Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан “Бага боловсролын монгол хэлний сургалтад ашиглах унших эхийн сан бүрдүүлэх” ажлын санхүүжилтийн зарим үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж ажиллалаа.

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн нь “Бага боловсролын монгол хэлний сургалтад ашиглах 1-5 дугаар ангийн эхийн сан бүрдүүлэх” ажлын цалин хөлсийг олгохдоо эх зохиогчдын гаргасан хүсэлтийн дагуу “Соёмбо принтинг ХХК”-тай 2024 оны №23/06-73 тоот гэрээ байгуулан цалин хөлсийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”-гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д “Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах” гэсэн заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.5-д “Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ”-гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Нэг. Цаашид холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу төлбөр тооцоог үнэн зөв, анхан шатны баримтад тулгуурлан хийж хэвших.

Хоёр. Албан шаардлагын биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Боловсролын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал М.Итгэл, нягтлан бодогч Б.Цэрэнханд нарт хариуцуулав.

Гурав. Энэхүү албан шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй бол Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 11.1-д “Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл түүнийг хүлээн авснаас хойш 10 хоногт багтаан Санхүүгийн хяналт шалгалтын улсын ерөнхий байцаагчид гомдол гаргана” -гэж заасны дагуу гомдол гаргах эрхтэй болно.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

БИЧСЭН:

ХШҮГ-ЫН ШИНЖЭЭЧ,
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ

О.БАЯРСҮРЭН



ХҮЛЭЭН АВСАН:

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ

М.ИТГЭЛ

НЯГТЛАН БОДОГЧ

Б.ЦЭРЭНХАНД

